ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН 15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:** ӨМА-2026/157/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг<br><br>2026 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Шижирболд<br>Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn<br>Аудитор: Т.Будсүрэн<br>Утас: 70533552 Цахим хаяг: Budsurent@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ……………………………………..……………..……3-4

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 Аудит хийсэн байдлын тайлан …………………………………………………….…………...5
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ……………………………………………..……………......6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ………………………………………………….7-8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан …………………....……….8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ……………………….………….…….…8-9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа …………………………………….…………..10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ……………………………………………………..10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал …………..……………………………..………10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ……..……11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл ………………………………………………………………..11
3.5.1 Төсвийн төлөвлөлт ……………………………………………….……..……11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ………………………………………………………..………..12
3.5.3 Нэмэлт төсөв …………………………………………………………..……………12

4. АУДИТЫН ТАЙЛАН
4.1 Ерөнхий зүйл ………………………...…………………………………..…………………..13
4.2 Материаллаг байдал ……………………………………………………………….………13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ………………………………………….…13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ……….…..13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ……………………………...……...…13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд …………………………………….………..14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ………………………….……..14
4.5.1 Завсрын аудитын талаар …………………………………….………..……..14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ……..……14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ………………………………………….………14

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ
5.1 Төлбөрийн акт ..........................................................................................................14
5.2 Албан шаардлага ......................................................................................................15
5.3 Зөвлөмж ....................................................................................................................15

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......................................16-17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.24 № 108

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНЛАЙ СУМЫН 15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Н.ХАШЧУЛУУ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Манлай сумын 15 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд албан хаагчдад хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүйгээр 27,904.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл, илүү цагийн хөлсийг байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй 39,524.6 мянган төгрөг олгосон нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 93,890.8 мянган төгрөг, Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 38,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал

4626050148

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 105,819.6 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 132,130.2 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшуулал, 23,390.4 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл 90,161.7 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт авсан байна.

**Бусад асуудал хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэн 88.7 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4 | 148,318,414.69 | 42,087,195.59 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | | 148,318,414.69 | 42,087,195.59 |
| **3121** | **Төгрөг** | | 148,318,414.69 | 42,087,195.59 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | | 148,318,414.69 | 42,087,195.59 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6 | 96,935,921.00 | 95,396,290.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | 96,935,921.00 | 95,396,290.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 37,150.00 | 260,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 24,337,725.00 | 17,400,205.00 |
| 35470 | Хүнсний материал | | 1,293,000.00 | 205,500.00 |
| 35460 | Бусад хангамжийн материал | | 71,268,046.00 | 77,530,585.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **245,254,355.69** | **137,483,485.59** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7 | 2,243,796,777.02 | 2,335,693,459.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 2,237,601,777.02 | 2,329,723,459.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 2,181,261,735.00 | 2,209,621,735.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (158,709,656.88) | (195,768,241.08) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 174,049,398.00 | 236,854,087.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (60,668,267.52) | (79,068,080.04) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 172,886,270.00 | 248,424,170.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (72,906,531.58) | (92,209,041.78) |
| 39214 | Ном | | 1,688,830.00 | 1,868,830.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 6,195,000.00 | 5,970,000.00 |
| 39301 | Программ хангамж | | 2,250,000.00 | 2,700,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,575,000.00) | (2,250,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 5,520,000.00 | 5,520,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **2,243,796,777.02** | **2,335,693,459.10** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **2,489,051,112.71** | **2,473,176,944.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 2,489,051,112,71 | 2,473,176,944.69 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 75,858,271.13 | 75,858,271.13 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 2,380,039,369.85 | 2,364,165,201.83 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 2,380,039,369.85 | 2,380,039,369.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | | (15,874,168.02) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 33,153,471.73 | 33,153,471.73 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **2,489,051,112.71** | **2,473,176,944.69** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **2,489,051,112.71** | **2,473,176,944.\69** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **955,570,500.00** | **1,024,994,900.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 860,902,600.00 | 920,484,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 860,902,600.00 | 920,484,100,00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 94,667,900,00 | 104,510,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 94,667,900.00 | 104,510,800.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **257,417,349.00** | **449,352,374.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 257,417,349.00 | 449,352,374.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 212,302,229.00 | 260,725,284.00 |
| 1200045 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 212,302,229.00 | 260,725,284.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 15,515,120.00 | 181,118,990.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 29,600,000.00 | 7,508,100.00 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,212,987,849.00** | **1,474,347,274.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,223,269,429.42** | **1,490,221,442.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,189,343,953.07** | **1,479,472,358.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **758,766,082.92** | **1,051,605,566.04** |
| 210101 | Үндсэн цалин | 516,249,533.02 | 667,280,289.94 |
| 210102 | Нэмэгдэл | 212,248,899.90 | 343,054,775.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 27,904,991.00 |
| 210104 | Урамшуулал | 30,267,650.00 | 13,365,509.26 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,925,997.86 | 131,963,737.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,528,503.89 | 89,821,006.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,826,882.90 | 10,639,924.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,857,341.55 | 5,319,912.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,542,653.99 | 5,236,538.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,170,615.53 | 20,946,354.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **91,982,253.65** | **90,161,716.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,546,384.65 | 6,693,847.19 |
| 210302 | Түлш, халаалт | 78,667,869.00 | 78,667,869.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,768,000.00 | 4,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,449,495.04** | **3,641,700.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,290,700.00 | 3,641,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 158,795.04 | |
| **2105** | **Норматив зардал** | **92,638,250.00** | **80,112,300.00** |
| 210502 | Хоол, хүнс | 92,638,250.00 | 80,112,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,876,000.00** | **4,376,611.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,876,000.00 | 4,376,611.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,543,600.00** | **3,005,700.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,543,600.00 | 3,005,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **139,162,273.60** | **114,605,027.92** |
| 210901 | Бараа үйлчилгээнй бусад зардал | 28,023,150.00 | 19,702,120.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,145,300.00 | 5,680,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 91,933,823.60 | 89,222,307.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,925,476.35** | **10,749,083.81** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,925,430.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33,925,430.00 | |
| 2133 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 46.35 | 10,749,083.81 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46.35 | 10,749,083.81 |
| | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.30** | |
| | Дотоод эх үүсвэрээр | 0.30 | |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.30 | |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,223,269,429.72** | **1,490,221,442.02** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(10,281,580.72)** | **(15,874,168.02)** |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(10,281,580.72)** | **(15,874,168.02)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,167,872,729.00** | **1,285,720,184.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 212,302,229.00 | 260,725,284.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 212,302,229.00 | 260,725,284.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 212,302,229,00 | 260,725,284.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 212,302,229.00 | 260,725,284.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **955,570,500.00** | **1,024,994,900.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 860,902,600.00 | 920,484,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 860,902,600.00 | 920,484,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 94,667,900.00 | 104,510,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 94,667,900.00 | 104,510,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,109,739,960.78** | **1,391,951,403.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,109,739,960.78** | **1,391,951,403.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,075,814,484.43** | **1,381,202,319.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **758,766,082.92** | **1,051,605,566.04** |
| 210101 | Үндсэн цалин | 516,249,533.02 | 667,280,289.94 |
| 210102 | Нэмэгдэл | 212,248,899.90 | 343,054,775.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 27,904,991.00 |
| 210104 | Урамшуулал | 30,267,650.00 | 13,365,509.26 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **95,925,997.86** | **131,963,737.06** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,528,503.89 | 89,821,006.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,826,882.90 | 10,639,924.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,857,341.55 | 5,319,912.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,542,653.99 | 5,236,538.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,170,615.53 | 20,946,354.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **91,982,253.65** | **90,161,716.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,546,384.65 | 6,693,847.19 |
| 210302 | Түлш, халаалт | 78,667,869.00 | 78,667,869.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,768,000.00 | 4,800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **93,601,450.00** | **78,408,800.00** |
| 210502 | Хоол, хүнс | 93,601,450.00 | 78,408,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,685,600.00** | **3,600,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,685,600.00 | 3,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,543,600.00** | **3,005,700.00** |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,543,600.00 | 3,005,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,309,500.00** | **22,456,800.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,421,900.00 | 16,422,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,887,600.00 | 6,034,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,925,476.35** | **10,749,083.81** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,925,430.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 33,925,430.00 | |
| 2134 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 46.35 | 10,749,083.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46.35 | 10,749,083.81 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **58,132,768.22** | **(106,231,219.10)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **58,132,768.22** | **(106,231,219.10)** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 148,318,414.69 |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 42,087,195.59 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 75,858,271.13 | 33,153,471.73 | 2,380,039,369.85 | 2,489,051,112.71 |
| CO5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 9,950,000.00 | | | 9,950,000.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (25,824,168.02) | (25,824,168.02) |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 75,858,271.13 | 33,153,471.73 | 2,380,039,369.85 | 2,489,051,112.71 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (15,874,168.02) | (15,874,168.02) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **75,858,271.13** | **33,153,471.73** | **2,364,165,201.83** | **2,473,176,944.69** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,181,391,300.00** | **1,024,994,900.00** | 156,396,400.00 | 86.76 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,054,751,600.00 | 920,484,100.00 | 134,267,500.00 | 87.27 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,054,751,600.00 | 920,484,100.00 | 134,267,500.00 | 87.27 |
| 132 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 126,639,700.00 | 104,510,800.00 | 22,128,900.00 | 82.53 |
| 132001 | Орон нутгийн төсөв | 126,639,700.00 | 104,510,800.00 | 22,128,900.00 | 82.53 |
| 120004 | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 325,076,100.00 | 260,725,284.00 | 64,350,816.00 | 80.20 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос сахнүүжих | 325,076,100.00 | 260,725,284.00 | 64,350,816.00 | 80.20 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,506,467,400.00** | **1,285,720,184.00** | 220,747,216.00 | 85.35 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,506,467,400.00** | **1,391,951,403.10** | 114,515,996.90 | 92.40 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,506,467,400.00** | **1,381,202,319.29** | 125,265,080.71 | 91.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,111,009,000.00** | **1,051,605,566.04** | 59,403,433.96 | 94.65 |
| 210101 | Үндсэн цалин | 669,471,500.00 | 667,280,289.94 | 2,191,210.06 | 99.67 |
| 210102 | Нэмэгдэл | 407,438,500.00 | 343,054,775.84 | 64,383,724.16 | 84.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 27,904,991.00 | (27,904,99.,00) | |
| 210104 | Урамшуулал | 34,099,000.00 | 13,365,509.26 | 20,733,490.74 | 39.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **135,272,000.00** | **131,963,737.06** | 3,308,262.94 | 97.55 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 91,787,100.00 | 89,821,006.95 | 1,966,093.05 | 97.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,871,200.00 | 10,639,924.34 | 231,275.66 | 97.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,435,600.00 | 5,319,912.17 | 115,687.83 | 97.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,435,600.00 | 5,236,538.72 | 199,061.28 | 96.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,742,500.00 | 20,946,354.88 | 796,145.12 | 96.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **122,639,700.00** | **90,161,716.19** | 32,477,983.81 | 73.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,000,000.00 | 6,693,847.19 | 5,306,152.81 | 55.78 |
| 210302 | Түлш, халаалт | 105,639,700.00 | 78,667,869.00 | 26,971,831.00 | 74.47 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 4,800,000.00 | 200,000.00 | 96.00 |
| **2105** | **Норматив зардал** | **98,921,900.00** | **78,408,800.00** | 20,513,100.00 | 79.26 |
| 210502 | Хоол, хүнс | 98,921,900,00 | 78,408,800.00 | 20,513,100.00 | 79.26 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,000,000.00** | **3,600,000.00** | 400,000.00 | 90.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 3,600,000.00 | 400,000.00 | 90.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,021,100.00** | **3,005,700.00** | 1,015,400.00 | 74.75 |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 4,021,100.00 | 3,005,700.00 | 1,015,400.00 | 74.75 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,603,700.00** | **22,456,800.00** | 8,146,900.00 | 73.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,723,500.00 | 16,422,200.00 | 7,301,300.00 | 69.22 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,880,200.00 | 6,034,600.00 | 845,600.00 | 87.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **10,749,083.81** | (10,749,083.81) | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | | 10,749,083.81 | (10,749,083.81) | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,749,083.81 | (10,749,083.81) | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 1,506,467,400.00 | 1,391,951,403.10 | 114,515,996.90 | 92.40 |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 148,318,414.69 | (148,318,414.69) | |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **42,087,195,59** | (42,087,195.59) | |
| 002 | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | **1.00** | | 100.00 |
| 005 | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | **30.00** | | 100.00 |
| 006 | **Удирдах ажилтан** | 1.00 | **1.00** | | 100.00 |
| 007 | **Гүйцэтгэх ажилтан** | 16.00 | **16.00** | | 100.00 |
| 008 | **Үйлчлэх ажилтан** | 13.00 | **13.00** | | 100.00 |
| 015 | **Төрийн өмчит СӨБ байгууллага** | 1.00 | | 1.00 | |
| 028 | **СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)** | 18.00 | | 18.00 | |
| 033 | **Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)** | 10.00 | | 10.00 | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 138,671.2 мянган төгрөгийн алдаа[6] илэрснээс аудитын явцад 138,671.2 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан,
- Үндсэн хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 17,740.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг Санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнтэй тулган баталгаажуулахад 225.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн хуримтлагдсан элэгдлийн зардалтай тулган баталгаажуулахад 87.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

- Мөнгөн гүйлгээний тайлан дах биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн худалдан авсан хөрөнгөтэй тулган баталгаажуулахад 450.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд НДШ-ийн өглөгийг 120,168.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тус тус зөрүүтэй тусгасан байна.

Энэ нь УСНББОУС-1,"Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 67,429.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 67,429.6 мянган төгрөгийн 2 зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

**ТӨЛБӨРИЙН АКТ:**

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

**АЛБАН ШААРДЛАГА:**

*Илрүүлэлт-1:* Тайлант онд хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй 27,904.9 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх",* Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3-д *"Ажил олгогч энэ хуульд зааснаас өөр төрлийн олговрыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоон олгож болно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэх

*Илрүүлэлт-2:* Тайлант онд байгууллагын албан хаагчдад "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй 39,504.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх",* Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлэгийн 1-т *"Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэх

**5.3 ЗӨВЛӨМЖ:**

Зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

***Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*** */мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан. | 1 | 0 | | | 1 | 0 | 1 | 0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн тайлангийн тусламж хандиваар авсан дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 17,740.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, | 1 | 17,740.2 | | | 1 | 17,740.2 | 1 | 17,740.2 | | | | |
| Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг Санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнтэй тулган баталгаажуулахад 225.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, | 1 | 225.0 | | | 1 | 225.0 | 1 | 225.0 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн хуримтлагдсан элэгдлийн зардалтай тулган баталгаажуулахад 87.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, | 1 | 87.4 | | | 1 | 87.4 | 1 | 87.4 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлан дах биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн худалдан авсан хөрөнгөтэй тулган баталгаажуулахад 450.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, | 1 | 450.0 | | | 1 | 450.0 | 1 | 450.0 | | | | |
| Санхүүгийн тодруулгын өглөгийн тайланд НДШ-ийн өглөгийг 120,168.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тус тус зөрүүтэй тусгасан | 1 | 120,168.5 | | | 1 | 120,168.5 | 1 | 120,168.5 | | | | |
| **Дүн** | **6** | **138,671.2** | | | **6** | **138,671.2** | **6** | **138,671.2** | | | | |

***Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | А/т/тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй 27,904.9 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл олгосон | 1 | 27,904.9 | | | 1 | 27,904.9 | | | | | | |
| Тайлант онд байгууллагын албан хаагчдад "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй 39,504.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон | 1 | 39,504.6 | | | 1 | 39,504.6 | | | | | | |
| **ДҮН** | **2** | **67,429.6** | | | **2** | **67,429.6** | | | | | | |

***Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал***

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны хуультай холбоотой зөрчил гараагүй байна. | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил гараагүй байна. | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |